

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/040/НА-СТА-ТШЗ

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 2 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 4 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ..... | 11 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 12 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|------------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХөрөнгө | Засаг даргын нөөц хөрөнгө |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын |



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.26 № 375

танай _____-ны № _____-т

**ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
ТАХИЛГАТ ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
Ө.ЗОРИГТ ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийг бусдад эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, ашиглалтын гэрээ байгуулаагүй ашиглуулсан, түлш, шатах тослох материалын үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй, хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтний орон тоонд төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй иргэнийг 2025 оны 4 дүгээр сараас түр томилон ажиллуулсан зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага” хөтөлбөр, 6 арга хэмжээний хүрээнд орон нутгийн төсвөөс 428,330.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 390.0 мянган төгрөг нийт 428,720.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэлээр 88.2 хувь буюу 378,274.5 мянган төгрөгийг зарцуулж, 50,446.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 2,135.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитаар мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 51,312.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,671.3 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, авто тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 37,900.0 мянган төгрөгийн пургон авто машиныг бусад төрийн байгууллагад эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, ашиглалтын гэрээ байгуулаагүй ашиглуулсан, түлш, шатах тослох материалын 3,900.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй, хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтний орон тоонд тусгай шалгалт өгөөгүй иргэнийг 2025 оны 4 дүгээр сараас томилон 4,799.1 мянган төгрөгийн цалин олгосон зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 6 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 88 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээш түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 19,907,200.00 | 19,781,250.00 |
| 33 | АВЛАГА | 890,000.00 | - |
| 335 | Бусад авлага | 890,000.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 890,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 19,017,200.00 | 19,781,250.00 |
| 354 | Хангамжийн материал | 19,017,200.00 | 19,781,250.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,789,800.00 | 3,093,150.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,227,400.00 | 12,531,900.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,000,000.00 | 3,942,200.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 214,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,438,075,310.59 | 1,338,104,073.10 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,438,075,310.59 | 1,338,104,073.10 |
| 392 | Биет хөрөнгө | 1,269,895,310.59 | 1,169,924,073.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,484,767,203.96 | 1,484,767,203.96 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (248,869,074.75) | (349,106,297.07) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 39,580,000.00 | 56,650,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (20,629,999.92) | (36,029,165.88) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 38,359,769.60 | 34,056,609.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (29,364,665.16) | (24,971,194.11) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,765,700.00 | 7,615,700.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (2,183,623.14) | (3,528,783.40) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 470,000.00 | 470,000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 168,180,000.00 | 168,180,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 168,180,000.00 | 168,180,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,457,982,510.59 | 1,357,885,323.10 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 2,767,107.94 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 2,767,107.94 |
| 413 | Өглөг | - | 2,767,107.94 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 328,883.94 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 1,636,174.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 802,050.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 802,050.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,457,982,510.59 | 1,355,118,215.16 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,457,982,510.59 | 1,355,118,215.16 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 263,499,828.00 | 263,499,828.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 263,499,828.00 | 263,499,828.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 738,912,455.79 | 636,048,160.36 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 738,912,455.79 | 738,583,571.85 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (102,535,411.49) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 455,570,226.80 | 455,570,226.80 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,457,982,510.59 | 1,357,885,323.10 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-------------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,172,321,124.00 | 443,173,911.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 740,852,312.00 | 12,708,334.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 740,852,312.00 | 12,708,334.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 740,852,312.00 | 12,708,334.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 740,852,312.00 | 12,708,334.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 431,468,812.00 | 430,465,577.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,029,512.00 | 2,134,977.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,679,512.00 | 784,977.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 426,439,300.00 | 428,330,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 426,439,300.00 | 428,330,600.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 484,472,295.76 | 545,709,322.49 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 484,472,295.76 | 545,709,322.49 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 341,466,249.81 | 494,063,185.22 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 171,910,226.25 | 269,929,726.23 |
| 210101 | Үндсэн цалин | 116,211,330.52 | 133,528,382.23 |
| 210102 | Нэмэгдэл | 39,719,846.52 | 75,000,649.93 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,555,000.00 | 12,715,000.00 |
| 210104 | Урамшуулал | 3,568,239.75 | 4,933,841.21 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,855,809.46 | 43,751,852.86 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 20,112,028.05 | 33,181,434.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,381,404.04 | 22,715,715.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,719,102.26 | 2,744,016.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,460,592.45 | 2,239,508.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 720,228.12 | 1,096,438.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,830,701.18 | 4,385,755.32 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,871,618.15 | 35,356,689.23 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,218,455.15 | 11,433,665.93 |
| 210302 | Түлш, халаалт | 23,653,163.00 | 23,923,023.30 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 28,325,402.00 | 18,414,147.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,176,200.00 | 2,190,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,639,602.00 | 11,246,247.50 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,353,000.00 | 1,206,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 850,000.00 | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,306,600.00 | 2,771,550.00 |
| 2105 | Нормативт зардал | 3,396,000.00 | 200,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,396,000.00 | 200,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,114,450.00 | 8,125,900.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 506,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 389,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,114,450.00 | 7,230,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,013,000.00 | 6,370,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,013,000.00 | 6,370,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,252,818.00 | 900,926.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,758,250.00 | 165,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 205,750.00 | - |

| | | | |
|-------------|---|------------------------------|--------------------------------|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95,200.00 | 190,018.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 12,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 110,618.00 | 83,408.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 74,470,707.36 | 121,584,361.49 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,534,400.00 | 5,524,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 67,936,307.36 | 116,059,461.49 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 143,006,045.95 | 51,646,137.27 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,205,900.00 | 1,200,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,758,900.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,447,000.00 | 1,200,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 125,800,145.95 | 50,446,137.27 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 125,800,145.95 | 50,446,137.27 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>687,848,828.24</u> | <u>(102,535,411.49)</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>687,848,828.24</u> | <u>(102,535,411.49)</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 431,468,812.00 | 430,855,577.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 390,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 390,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 390,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 390,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 431,468,812.00 | 430,465,577.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,029,512.00 | 2,134,977.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,679,512.00 | 784,977.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 426,439,300.00 | 428,330,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 426,439,300.00 | 428,330,600.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 419,091,812.00 | 427,475,687.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 419,091,812.00 | 427,475,687.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 276,085,766.05 | 375,949,549.73 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 171,910,226.25 | 270,049,726.23 |
| 210101 | Үндсэн цалин | 116,211,330.52 | 133,648,382.23 |
| 210102 | Нэмэгдэл | 39,719,846.52 | 75,000,649.93 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,555,000.00 | 12,715,000.00 |
| 210104 | Урамшуулал | 3,568,239.75 | 4,933,841.21 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,855,809.46 | 43,751,852.86 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19,881,301.65 | 33,181,434.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,150,677.64 | 22,715,715.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,719,102.26 | 2,744,016.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,460,592.45 | 2,239,508.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 720,228.12 | 1,096,438.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,830,701.18 | 4,385,755.32 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,871,618.15 | 37,113,781.73 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,218,455.15 | 11,433,665.93 |
| 210302 | Түлш, халаалт | 23,653,163.00 | 25,680,115.80 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 25,344,340.00 | 14,704,031.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,997,600.00 | 1,769,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,708,340.00 | 9,570,181.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,445,000.00 | 1,496,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,110,000.00 | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,083,400.00 | 868,750.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,485,500.00 | 800,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,485,500.00 | 800,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,883,300.00 | 4,440,150.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 670,000.00 | 1,383,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,200,000.00 | 504,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,013,300.00 | 2,552,650.00 |
| 2107 | Томилот, зочны зардал | 1,013,000.00 | 6,370,000.00 |
| 210702 | Дотоод албан томилот | 1,013,000.00 | 6,370,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,057,080.00 | 2,513,526.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,012,512.00 | 1,777,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 205,750.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95,200.00 | 191,298.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 12,500.00 |

| | | | |
|-------------|--|------------------------|-----------------------|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 110,618.00 | 82,128.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,639,400.00 | 6,776,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,639,400.00 | 6,776,900.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 143,006,045.95 | 51,526,137.27 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,205,900.00 | 1,080,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,758,900.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,447,000.00 | 1,080,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 125,800,145.95 | 50,446,137.27 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 125,800,145.95 | 50,446,137.27 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 12,377,000.00 | 3,379,890.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 12,377,000.00 | 3,379,890.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 12,377,000.00 | 3,379,890.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 12,377,000.00 | 3,379,890.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 12,377,000.00 | 3,379,890.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (12,377,000.00) | (3,379,890.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|-------|---|
| С01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 263,499,828.00 | 455,570,226.80 | 738,912,455.79 | - | 1,457,982,510.59 |
| С02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| С03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 263,499,828.00 | 455,570,226.80 | 738,912,455.79 | - | 1,457,982,510.59 |
| С04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - | - |
| С05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - | - |
| С06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| С07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (97,277,026.43) | - | (97,277,026.43) |
| С08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 263,499,828.00 | 455,570,226.80 | 641,635,429.36 | - | 1,360,705,484.16 |
| Д01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 263,499,828.00 | 455,570,226.80 | 641,635,429.36 | - | 1,360,705,484.16 |
| Д02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (328,883.94) | - | (328,883.94) |
| Д03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 263,499,828.00 | 455,570,226.80 | 641,306,545.42 | - | 1,360,376,600.22 |
| Д04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| Д05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| Д06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| Д07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| Д08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (102,535,411.49) | - | (102,535,411.49) |
| Д09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 263,499,828.00 | 455,570,226.80 | 538,771,133.93 | - | 1,257,841,188.73 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 428,330,600.00 | 377,884,462.73 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 428,330,600.00 | 377,884,462.73 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 426,747,600.00 | 376,804,462.73 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 298,174,000.00 | 269,659,726.23 |
| 210101 | Үндсэн цалин | 153,843,100.00 | 133,648,382.23 |
| 210102 | Нэмэгдэл | 75,930,900.00 | 75,000,649.93 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,500,000.00 | 12,715,000.00 |
| 210104 | Урамшуулал | 8,500,000.00 | 4,933,841.21 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 43,400,000.00 | 43,361,852.86 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,434,300.00 | 33,181,434.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,591,300.00 | 22,715,715.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,010,700.00 | 2,744,016.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,305,400.00 | 2,239,508.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,505,400.00 | 1,096,438.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,021,500.00 | 4,385,755.32 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 39,222,000.00 | 37,113,781.73 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,466,000.00 | 11,433,665.93 |
| 210302 | Түлш, халаалт | 25,756,000.00 | 25,680,115.80 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,740,000.00 | 12,734,054.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,500,000.00 | 1,769,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,500,000.00 | 7,600,204.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,700,000.00 | 1,496,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,000,000.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 1,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,040,000.00 | 868,750.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,350,000.00 | 800,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,350,000.00 | 800,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,195,200.00 | 7,655,040.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,655,200.00 | 4,598,390.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 540,000.00 | 504,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,000,000.00 | 2,552,650.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,000,000.00 | 6,370,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,000,000.00 | 6,370,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,932,100.00 | 2,513,526.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,832,900.00 | 1,777,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,200.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 550,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 205,000.00 | 191,298.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 12,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 550,000.00 | 82,128.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,700,000.00 | 6,776,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,700,000.00 | 6,776,900.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,583,000.00 | 1,080,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,583,000.00 | 1,080,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,583,000.00 | 1,080,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 428,330,600.00 | 378,274,462.73 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 428,330,600.00 | 377,884,462.73 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 428,330,600.00 | 377,884,462.73 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | - | 390,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 390,000.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|------------|--|--------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,134,977.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,134,977.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,134,977.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,969,977.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,969,977.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 165,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 165,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,134,977.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,134,977.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 784,977.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,350,000.00 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 4,671.3 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Үүнд:

Залруулсан алдаа:

- Бараа материалын тайлангийн сэлбэг хэрэгсэл дансны 360.0 мянган төгрөгийн материалын зарлагыг цалингийн зардлаар бүртгэснийг залруулж бүртгэв.
- Үндсэн хөрөнгийн тодруулгын болон дэлгэрэнгүй тайлангаарх хуримтлагдсан элэгдэл, тайлант оны элэгдлийн зардлыг 4,311.3 мянган төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулав.

Аудитаар нийт 46,641.3 мянган төгрөгийн зөрчил илэрч, 3 албан шаардлага хүргүүлэв.

3.1 Албан шаардлага

1. Үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 37,900.0 мянган төгрөгийн пургон авто машиныг Хэрлэн сумын Засаг даргын тамгын газарт Орон нутгийн өмчийн газрын шийдвэргүй, ашиглалтын гэрээ байгуулаагүй ашиглуулж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно." гэж заасныг зөрчсөн байна.

2. Бараа материалын түлш, шатах тослох материалын 3,602.2 мянган төгрөгийн нүүрс, 340.0 мянган төгрөгийн түлшний үлдэгдлийг жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор тоолоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.", 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс"/, 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

3. Захирагчийн ажлын албаны Хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтний сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй, нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг 2025 оны 3 дугаар сараар томилон ажиллуулж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.", 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараахь тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно" гэснийг зөрчсөн байна.

Санхүүгийн аудитын асуудлаар илрүүлсэн 41,842.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|--|------------|----------------|-----------------------------------|----------|--------------------------|----------------|------------|----------------|-----------------|----------|----------|----------|
| | | | | | | | Залруулсан | | Залруулагдаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын зарлагыг цалингийн зардалд бүртгэсэн. | 1 | 360.0 | | | 1 | 360.0 | 1 | 360.0 | | | | |
| Элэгдэл дутуу бүртгэсэн | 1 | 4,311.3 | | | 1 | 4,311.3 | 1 | 4,311.3 | | | | |
| Дүн | 2 | 4,671.3 | - | - | 2 | 4,671.3 | 2 | 4,671.3 | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|----------|----------|--------------------------------------|----------|---|----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тээврийн хэрэгсэл бусдад үндэслэлгүй ашиглуулсан. | 1 | 37,900.0 | | | 1 | 37,900.0 | | | | | | |
| Бусад хангамжийн материалыг тоолоогүй. | 1 | 3,942.2 | | | 1 | 3,942.2 | | | | | | |
| Дүн | 2 | 41,842.2 | | | 2 | 41,842.2 | - | - | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|----------------|---------------|----------|-----------------|----------------|----------|----------|----------|----------|----------|----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Мэдээллийг дутуу мэдээлсэн. | | | | | | | | | | | | |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлээгүй | 1 | 4,799.1 | | | 1 | 4,799.1 | | | | | | |
| Дүн | 1 | 4,799.1 | - | - | 1 | 4,799.1 | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | 1 | 4,799.1 | - | - | 1 | 4,799.1 | - | - | - | - | - | - |



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 118 - А 2370448

Чингис хот

ХЭА-2026/040/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захирагчийн ажлын албаны Хүнс, хөдөө аж ахуйн мэргэжилтний сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй, нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг 2025 оны 3 дугаар сараар томилон ажиллуулж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.", 42 дугаар зүйлийн 42.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараахь тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно" гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал, бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон гарсан тохиолдолд олон нийтэд мэдээлдэггүй, төрийн албаны шалгалт өгөөгүй албан хаагчаар гүйцэтгүүлдэг зөрчлийг арилган, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирагч Ө.Зоригт-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 119-А2370448

Чингис хот

ХЭА-2026/040/НА-СТА-ТШ5

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын түлш, шатах тослох материалын 3,602,200.0 (гурван сая зургаан зуун хоёр мянга хоёр зуу) төгрөгийн нүүрс, 340,000.00 (гурван зуун дөчин мянга) төгрөгийн түлшний үлдэгдлийг жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор тоолоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.", 70.2.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1. 12 дугаар сарын 1-нээс", 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын үлдэгдлийг тоолж, баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг нягтлан бодогч Ц.Хуланд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 120-А 2370448

Чингис хот

ХЭА- 2026/040/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Хэрлэн сумын Тахилгат тосгоны Захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн авто тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 37.900.000 00 (гучин долоон сая есөн зуун мянга) төгрөгийн фургон авто машиныг Хэрлэн сумын Засаг даргын тамгын газарт Орон нутгийн өмчийн газрын шийдвэргүй, ашиглалтын гэрээ байгуулаагүй ашиглуулж байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.3-т "өмч, хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Орон нутгийн өмчийг эрх бүхий этгээдийн шийдвэргүй бусдад ашиглуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг захирагч Ө.Зоригт-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА